



ЭМНЭЛ ЗҮЙН ЭМГЭГ СУДЛАЛ

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Сүүлийн 5 жилийн ажлын тайлан /удирдах ажилтны тамга, гарын үсгээр баталгаажсан байна /;
2. Жилд мэргэшлийн чиглэлийн 6-аас доошгүй багц цагийн сургалтад хамрагдсан байх /гэрчилгээ, тодорхойлолтоор баталгаажсан байна /;
3. Сүүлийн 5 жилд тухайн лабораторид 3-аас доошгүй шинэ арга технологи, ашигтай загвар нэвтрүүлсэн байх /гэрчилгээ, тодорхойлолтоор баталгаажсан байна/;
4. Сүүлийн 5 жилд шинжилгээний заавар, удирдамж, стандарт 3-аас доошгүй боловсруулсан байх /боловсруулсан баримт бичгийн хуулбараар баталгаажсан байна/;
5. Лабораторийн оношилгооны чиглэлээр 5-аас доошгүй жил тусламж үзүүлсэн туршлагатай байх /эмч нарын тойрон үзлэг, зөвлөгөөн, эмгэг анатомийн хуралд оролцож хийсэн мэдээлэл-протоколоор баталгаажсан байна/;
6. Сүүлийн 5 жилд мэргэшлийн чиглэлээр тухайн эмнэлгийн эмч нарт 5-аас доошгүй удаа хичээл заасан байх /сургалтын материал, эмнэлгийн сургалтын албаар баталгаажсан байна/;
7. Мэргэжлийн англи хэлний зохих түвшингийн мэдлэгтэй байх /гэрчилгээгээр баталгаажсан байна/;
8. Компьютерийн мэдлэгийн зохих түвшин хангасан /гэрчилгээгээр баталгаажсан байна/;
9. Сүүлийн 5 жилд өгүүлэл, илтгэлийн 5-аас доошгүй хураангуй нийтлүүлсэн байх /өгүүлэл, илтгэлийн хураангуйн хуулбараар баталгаажсан байна/;
10. Сүүлийн 5 жилд салбар, байгууллагаа хөгжүүлэх төсөл боловсруулж хэрэгжүүлсэн байх /холбогдох байгууллагын тодорхойлолтоор баталгаажсан байна/.

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Ахлах зэрэг хамгаалснаас хойш 5 жил тасралтгүй ажилласан байх /мэргэшлийн зэргийн үнэмлэхийн эх хувиар баталгаажсан байна/;
2. Сүүлийн 5 жилийн ажлын тайлан /удирдах ажилтны тамга, гарын үсгээр баталгаажсан байна/;
3. Жилд мэргэшлийн чиглэлээр 6-аас доошгүй удаа багц цагийн богино сургалтад хамрагдсан байх /гэрчилгээ, тодорхойлолтоор баталгаажсан байна/;
4. Сүүлийн 5 жилд тухайн лабораторид 4-өөс доошгүй шинэ арга технологи, ашигтай загвар нэвтрүүлсэн байх /гэрчилгээ, тодорхойлолтоор баталгаажсан байна/;
5. Сүүлийн 5 жилд шинжилгээний заавар, удирдамж, стандарт 5-аас доошгүй боловсруулсан байх /боловсруулсан баримт бичгийн хуулбараар баталгаажсан байна/;
6. Лабораторийн оношилгооны чиглэлээр 10-аас доошгүй жил тусламж үзүүлсэн туршлагатай байх /эмч нарын тойрон үзлэг, зөвлөгөөн, эмгэг анатомийн хуралд оролцож хийсэн мэдээлэл-протоколоор баталгаажсан байна/.
7. Сүүлийн 5 жилд мэргэжлийн чиглэлээр тухайн эмнэлгийн эмч нарт 10-аас доошгүй удаа хичээл заасан байх /сургалтын материал, эмнэлгийн сургалтын албаар баталгаажсан байна/;
8. Мэргэжлийн англи хэлний зохих түвшингийн мэдлэгтэй байх //гэрчилгээгээр баталгаажсан байна/;
9. Компьютерийн мэдлэгийн зохих түвшин хангасан /гэрчилгээгээр баталгаажсан байна/;
10. Сүүлийн 5 жилд өгүүлэл, илтгэлийн 5-аас доошгүй хураангуй нийтлүүлсэн байх /өгүүлэл, илтгэлийн хураангуйн хуулбараар баталгаажсан байна/;
11. Сүүлийн 5 жилд салбар, байгууллагаа хөгжүүлэх төсөл боловсруулж хэрэгжүүлсэн байх /байгууллагын даргын тодорхойлолтоор баталгаажсан байна/.

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Сүүлийн 5 жилийн ажлын тайлан /удирдах ажилтны тамга, гарын үсгээр баталгаажсан байна/;
2. Жилд мэргэшлийн чиглэлээр 6-аас доошгүй удаа багц цагийн богино хугацааны сургалтад хамрагдсан байх /гэрчилгээ, тодорхойлолтоор баталгаажсан байна/;
3. Сүүлийн 5 жилд тухайн лабораторид 5-аас доошгүй шинэ арга технологи, ашигтай загвар нэвтрүүлсэн байх /гэрчилгээ, тодорхойлолтоор баталгаажсан байна/;
4. Сүүлийн 5 жилд шинжилгээ, мэргэшил арга зүйн чиглэлээр бодлогын баримт, бичиг боловсруулахад 8-аас доошгүй боловсруулсан байх /боловсруулсан баримт бичгийн хуулбараар баталгаажсан байна/;

5. Лабораторийн оношилгооны чиглэлээр 15-аас доошгүй жил тусламж үзүүлсэн туршлагатай байх /эмч нарын тойрон үзлэг, зөвлөгөөн, эмгэг анатомийн хуралд оролцож хийсэн мэдээлэл-протоколоор баталгаажсан байна/;
6. Сүүлийн 5 жилд мэргэшлийн чиглэлээр тухайн эмнэлгийн эмч нарт 15-аас доошгүй удаа хичээл заасан байх /сургалтын материал, эмнэлгийн сургалтын албаар баталгаажсан байна/;
7. Лабораторийн мэргэжилтэн бэлтгэх сургалтад сургагч багшаар ажилласан байх /тушаал, үнэмлэх, тайлангаар баталгаажсан байна/;
11. Мэргэжлийн англи хэлний зохих түвшингийн мэдлэгтэй байх /гэрчилгээгээр баталгаажсан байна/;
12. Компьютерийн мэдлэгийн зохих түвшин хангасан /гэрчилгээгээр баталгаажсан байна/;
13. Сүүлийн 5 жилд өгүүлэл, илтгэлийн 8-аас доошгүй хураангуй нийтлүүлсэн байх /өгүүлэл, илтгэлийн хураангуйн хуулбараар баталгаажсан байна/;
14. Сүүлийн 5 жилд салбар, байгууллагаа хөгжүүлэх төсөл боловсруулж хэрэгжүүлсэн байх /байгууллагын даргын тодорхойлолтоор баталгаажсан байна /.